

ТӨВ АЗИЙН УЛС ОРНУУДЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАСАГЛАЛЫН

ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ, ХАНДЛАГА

(Узбекстан, Туркменстан, Казахстаны жишигийн дээр)

Э.ДОВЧИН

Доктор профессор, МУПС, ИУС. Нийгэмийн Ухааны Салбар,

Улс Төр Судлалын тэнхим

Т.ТОЛКЫН

Докторант

Түүхүүр үг: Ерөнхийлөгч, парламентын засаглал, ерөнхийлөгчийн засаглал, эрх мэдэл, эрх үүрэг, ерөнхийлөгчийн тухай хууль, хориг тавих, вотум, томилгоо, удирдлага, аюлгүй байдал, эдийн засаг, сонгууль, парламент

ABSTRACT: Institutional design can impact the dynamics of power relations in Central Asian states. Majoritarianism and the rigidity of the fixed terms of presidential systems are amplified by the personalist regimes of Central Asia, often leading to instability. A parliamentary system may reduce the political repression of these regimes by decreasing the stakes in each particular election. It may also increase stability due to the higher flexibility of the system. The effectiveness of the parliamentary system, however, depends largely on the existence of strong cohesive parties.

The present day Central Asian States, namely, Uzbekistan, Turkmenistan, Kyrgyzstan, Tajikistan, and Kazakhstan, came into being after the October revolution in 1917. They owe their existence to the Soviet nationality policy. Looked at from this perspective, they have, indeed, a short history as independent, separate nations. However, they share a host of common specifics, which include a common Turkic ethnicity, a Common Muslim Cultural tradition and language, a similarity of history, predominance of rural population, low socio-economic mobility, low level of technical skills and qualifications. Tajiks like to project their somewhat different identity in terms of Persian language, which was, in fact, the language of local rulers and elite before the advent of Turks and their language in Central Asia. The apparent homogeneity is, however, quite deceptive. There exists a large diversity, which is articulated in many significant ways. For example, Uzbeks, who constitute the largest national group of over 17 million people, take pride in projecting their ethnic/national identity not entirely in terms of religious (sunni) or linguistic (Turkic) bonds, but primarily in terms of superior urban civilization which had developed by the side of Amu-Darya and Syr-Darya. Tajiks also consider themselves as sedentary. As against this, Turkmens and Kyrgyz are basically nomadic. Therefore, their geo-cultural identity is restricted, political regimes of the Central Asian states.

Uzbekistan cannot be likened to Kyrgyzstan in terms of the democracy index because the latter does not have a consolidated autocracy. The two regimes are similar because of their low IPI, which threatens their stability; in fact, this means the potentially low stability of their political regimes because governance is personalized.

These regimes can be described as a constitutional because their presidents do not rely on any party and do not regard political parties as an important instrument of their political domination, which might undermine the regime.

In these states, the president's powers are regularly revised, largely by amending the Constitution and using other methods.

Өнөөдөр дэлхийн улсууд засаглалын хувьд Бүгд найрамдах ба Хаант гэсэн хоёр үндэсн хэлбэртэй байна.¹ Бүгд найрамдах засгийн хэлбэр нь анхлан МЭӨ 509 оцд эртний Ромын язгууртнууд болох патрицууд Эзэн хаан Бардам Тарквин I-ыг хаан ширээнээс нь түүхэн унагаж төрийн эрхлийг сенатад шилжүүлснээс үүссэн юм. Орчин үед бүгд найрамдах засаглалын парламетын ба Ерөнхий өгчийн гэж ялгарж байгаа. Бүгд найрамдах засаглалтай улсад хууль боловсруулах болон батлах эрхийг бүх нийтийн сонгуулиар байгуулагдсан төрийн эрх барих дээд байгууллага болох парламент эзэлнэ. Парламентийг уле орон бүр өөр өөрийнхөөрөө тухайлбал Монгол улсад УИХ, АНУ-д Конгресс, ОХУ-д Төрийн Дум, Польшид Сейм, Германы Бундестаг гэх мэтээр иэрлэнэ. Парламент нь сайд нарын танхмыг буруу, тж, ерөнхий сайдыг сонгоно. Мөн үндэсн хуулийн хяналтын болон төрийн бусад байгууллагыг томилж. Энэ нь парламентын болно. Засаглалын ерөнхий жишиг парламент нь төрийн тэргүүн ерөнхийлөгч сонгоно. Бүгд Найрамдах засаглалын хэлбэрийг үндэсний төр дийлэнд олонхи нь сонгосон байдал. Парламентийг бүх нийтийн сонгуулиар буруулах ба гол төлөв дээд танхимуудыг шууд буе сонгуулиар

¹ Nelson, Dana D. (2008). Bad for Democracy: How the Presidency Undermines the Power of the People.

дамжуулан бүрдүүлдэг. Ард түмэн нь иргэний ба улстөрийн хувьд өргөн эрх эдэлдэг.

Ерөнхийлөгчийн засаглал² хэмээх төрийн засаглалын бас нэг хувилбарыг 1776 онд америкичууд бодож олжээ. Хууль тогтоох хурал болон ерөнхийлөгч нь тустуудаа сонгуулиар бие даан сонгогдоно. Ерөнхийлөгч улс орноо төлөөлөхөөс гадна гүйцэтгэх засгийг толгойлж Засгийн газраа өөрөө байгуулна. Ийм засаглалтай орны тоонд Латин Америк ба бараг Африкийн бүх орон багтдаг байна. XYIII зуны дундуур америкичууд Африкт “эрх чөлөө” гэсэн утга бүхий нэртэй Либэри улсыг байгуулж АНУ-ын Үндсэн хуулийн хуулбараар цогшиуулсан боловч шоглоомтой юм шиг энэ орон 150 жил самууны уурхай болсоор явна. Америкийн системийг нэлээд тууштай хэрэгжүүлж байсан Чили улс 1973 онд төрийн эргэлт хийсэн билээ. 100 орчим жил үймж бужигнасан явсан 1921 оноос Америкийн системийг тасралтгүй авч яваа байгаа үлгэр жишээ орноор тодорч буй нь асуудал өөрслөд нь биш. Харин хершид нь байна гэж тайлбарлах нь цөөнгүй. Америкийн засаглал орон бүрт хөрсөнд бууж таарахгүй байна гэж зарим судлаачид үздэг байна. Ялангуяа түүний практикаар баяжсаар ирсэн тангаргатны шүүхийн тогтолцоо орон бүрт санаан зоргоор таарахгүй гэж үздэг.

Парламентын ба Ерөнхийлөгчийн засаглалын аль нь хувилбарыг хамгийн олон туршсан улс орон бол Францын бүгд найрамдах улс билээ. 1958 онд генерал де Голлийн саналаар тав дахь Үндсэн хуулийг баталж Ерөнхийлөгчийн хагас засаглал гэсэн дундуур хувилбар буй болжээ. Ард түмнээс сонгогдсон Ерөнхийлөгч улсаа төлөөлөхөөс гадна гүйцэтгэх засаглал тэргүүний үүүргийг гүйцэтгэнэ. Парламент Ерөнхийлөгчийн санал болгосон Засгийн газрыг томилоно. Үүний зэрэгцээ Ерөнхийлөгчтэй зэрэгцээр Ерөнхий сайд гүйцэтгэх засаглалыг удирдана. Иймээс “Dual Executive”, “Cohabitation” гэсэн нэр томъёнууд Францын улс төртэй холбоотой юм. Иймээс Ерөнхийлөгч Ерөнхий сайдыг санал болгоходо парламент дахь хүчиний харьцааг заавал харж үзэхээс өөр аргагүй болдог. Өөрөөр хэлбэл, Засгийн газар нь парламентын бүтээл мөн боловч энэ нь Ерөнхийлөгчид таалагдах ёстой хэмээн нөгөө талаас нь ч бас тайлбарлаж болно. Энэхүү Ерөнхийлөгчийн хагас засаглалтай оронд Солонгос, Тайванаас гадна Орос, Польш, Чех гээд зарим хуучин коммунист ихэнх орнууд энэ хувилбарыг сонгож авсан билээ. Тэгэхээр манайхны яриад хүсээд буй Ерөнхийлөгчийн засаглал, сонгодог ардчилсан Ерөнхийлөгчийн засаглалын талаар зарим ялгааг тунгаах хэрэгтэй.

1. АНУ-ын Ерөнхийлөгчийн институцийг манайхан хялбар ойлгох нь бий. Үндэснээ шал ондоо юм. Гүйцэтгэх засаглалаа Ерөнхийлөгч нь тэргүүлдэг энэ хэлбэрийг америкичууд тусгаар тогтнолоо байлдан олоод Эзэн хаант засаглалын (Британийг сөргүүлж) нөгөө нэг хувилбар гэж сонгон авсан. Гэвч энд хүчтэй парламент ажиллаж байна. Учир нь Дэд ерөнхийлөгч нь парламентаа тэргүүлдэг тул харицан хяналт тавьж хүчийг нь тэнцүүлдэг. Ерөнхийлөгч ганц хүний тогтолтыг хуулиараа хязгаарлаж байна. Ийм системийг Америк тив тэр чигээрээ (Канад, Кубаас бусад), Азиас Индонез, Филиппин авсан ба тухайн улс тус бүр дээр бас онцлогууд бий. Өмнөд Солонгос, Тайваньд хүчтэй Ерөнхийлөгч байх ба тэд бүх ард түмнээсээ сонгогддог, парламентаасаа бас хамааралтай байдаг.

2. Бүх ард түмний сонгуулиар ялсан намын лидер нь шууд Ерөнхийлөгч болж Засгийн газраа байгуулан тэргүүлдэг Өмнөд Африкийн бас нэг засаглал бий. Хэрэв сөрөг хүчиний нам удаалсан бол хувь тэнцүүлж байгаад сөрөг хүчиний лидерийт дэд ерөнхийлөгч болгодог. Африкийн бусад улсуудын хувьд ерөнхийдөө гүйцэтгэх засаглалаа тэргүүлдэг американы тогтолцоо үйлчилдэг.³

3. Францад Ерөнхийлөгч, парламентыг ард түмнээс солбиуулж сонгодог нь манайтай төстэй. Аль аль талаасаа хяналттай, гэхдээ Ерөнхийлөгч нь Үндсэн хуулиараа Засгийн газраасаа илүү эрх дархтай⁴. Олон улсын дээд хэмжээний уулзалтад Францыг Ерөнхийлөгч, Ерөнхий сайд хоёул төлөөлэн оролцдог нь ч тэндхийн нэг онцлог юм. Францынхтай оролцоо тогтолцоо Египет, Шри Ланка, зарим талаар Пакистанд байна. Шууд адилтгаж бас болохгүй.

4. Үндэсний эв нэгдлийн бэлгэдэл болж, ёслолын чанартай үүрэг гүйцэтгэдэг Ерөнхийлөгч Энэтхэг, Бангладеш, Израиль, Итали, Австри, Сингапур зэрэг улсуудад байна.

Ерөнхийлөгчийн засаглалтай гэгдэх Төв Азийн зарим орны төрийн засаглалын хэлбэрийг эдийн засаг нийгмийн хөгжилтэй нь холбон авч үзье. ЗСБНХУ-ыг тарааж, суурин дээр нь 12 улс (ТУХН) Ерөнхийлөгчийн засаглалыг сонгосон. Тэр үед тэгхээс өөр нөхцөл байгаагүй, үндэсний эв нэгдэл, нийгмийн тогтвортой байдал нэн чухлаар тавигдсан, одоо ч хэрэгтэй байгаа нөхцөлд салж тусгаарласан, дөнгөж тусгаар тогтиносон шинэхэн улс үндэстнүүдэд ардчиллаас илүүтэй, ямар нэгэн “Үндэсний эшэг” хэрэгтэй байсан нь мэдээж. Тиймдээ ч тэр дурд Ельцин, Назарбаев, Акаев, Каримов, Ниязов,

² Bender, Thomas (2006). A Nation Among Nations: America's Place in World History. New York: Hill & Wang. p. 61 ISBN 978-0-8090-7235-4

³ Governing Systems and Executive-Legislative Relations (Presidential, Parliamentary and Hybrid Systems). United Nations Development Program

⁴ М.Дюверже Улс төрийн байгууламж, үндсэн хуулийн эрх зүй. p 390

Рахмонов, Алиев, Шевардназе нар онцийн саадгүй тэнцсэн юм. Төв Азийн орнууд үндэсний төрт ёсны уламжлалгүй, засаглалын бүтэцгүй, үндэсний зэвсэгт хүчингүй, тэр ч бүү хэл Үндсэн хуульгүй байхдаа эв найртай салж, тусгаар тогтолоо дор бүрнээ бэлэг болгон авсаасан. Тэрэнтэй харьцуулбал тусгаар тогтолын изн баялаг түүхтэй, эртний үндэстний хувьд монголчуудад “Үндэсний эзгийн” хэрэгцээ, нийгмийн захиалга Төв Азийн улсорнууд шиг байгаагүй.

Гэтэл Ерөнхийлөгчийн хүчтэй засаглалтай гээд буй ТУХН-ийн орнуудад засаглалын хямрал чинээндээ тулж байсан гашуун жишээ олыг дурдаж болж байна. 1993 оны хавар, намрын Москвагийн Мөргөлдөөн, цус урсгалсан зэвсэгт тэмцэл, Тажикстаны 10 жилийн прогний дайн, Казахстаны Ерөнхий сайд нь сөрөг хүчинэ толгойлж хөөгдөж гарал Троцкий шигэдүгээ Вашингтонос тэмцлээ үргэлжлүүлж байгаа. Ашхабадад Ерөнхийлөгчөө алахаар завсан, Гүрж. Азербайжанд болсон удаа дараагийн төрийн эргэлтүүд, Молдов дахь зэвсэгт мөргөлдөөн ба үндэсний хуваагдал, Орос, Беларусь, Украинад удаа дараа Засгийн газраа халсан сольсон гэхчлэн бүгд ардчиллын эсрэг, хууль бус эдгээр шийдлүүд Ерөнхийлөгчийн засаглалынх нь “ид шидийг” үзүүлж байна гэж хэлж болохоор байна.

Төв Азийн орнуудад Ерөнхийлөгчийн шударга ардчилсан сонгууль явуулахын оронд бүрэн эрхийн хугацааг нь ард түмнээрээ сунгуулдаг хачин жигтэй жишиг тогтоов. Ерөнхийлөгчийн эрх мэдэл илт давуут “Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн дагуу ганцаарчлан төр барих” гэгчээрээ зөвтгөж, тогтвортой байдал хэмээх лут үгээр халхвчлах болж байна. Ийм нөхцөлд улс төрийн дааштай сөрөг хүчин нийгэмд бүрэлдэх тухай яриа байж таарахгүй, энэ нь хэтрээд ард түмний тэвчээрийг барагдмагц “Цэцгийн хувьгал” гэгч дэгдэж, заримыг нь хөөж тараажээ.

Бүгд найрамдах засаглалтай ихэнх орнууд ерөнхийлөгчийн засаглалыг сонгосон бөгөөд цөөн хэдэн орон ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглалын шинжийг агуулсан холимог хэв шинжийн засаглалтай. Тухайлбал Монгол улсад Засгийн газрыг УИХ-аас томилон байгуулдаг бөгөөд Үндсэн хуулиар бол МУ-ын Ерөнхийлөгч ба УИХ-ын аль нь бие биенийгээ огцруулах эрхтэй байдаг байна. Харин, Төв Азийн дурдсан улсуудын засаглалыг авторитарт дэлгэм гэж ихэнх судлаачид үздэг ч тухайн ард түмэн, улс өөрсдийгөө хаант засагтай биш бүгд найрамдах ардчилсан улс гэжтүүнхагладаг.

Ардчилсан улсын шинж нь:⁵

- Засгийн газар байгуулах
- Тодорхой хугацаанд сонгууль явуулах
- Сонгогчдын эрхийг хангах

Хэн тэр засгийг байгуулж байна, мөн хэний удирдлагад, хэнд ажлаа тайлagnаж хариуцлага хүлээнэүүнээс үүдэн улсууд ерөнхийлөгчийн, парламентын болон холимог засаглалтай болж хуваагддаг.

Узбекстан, Казахстан, Туркменистанд Ерөнхийлөгч нь Парламентаас хараат бүс⁶, ард түмнээсээ сонгогддог. Ерөнхийлөгч нь төрийн тэргүүний үүргийг гүйцэтгэдэг. Ерөнхийлөгч нь тэр засаг, засгийн газраа өөрөө бүрдүүлдэг.⁷ Мөн тэдгээрийн ажлыг өөрөө удирдан зохион байгуулдаг. Эдгээр улсуудын парламент төр засагтаа итгэхгүй байх хотум хийж чадлагүй, ерөнхийлөгч нь парламентаа тараахгүй, харин цөөн тохиолдолд Казахстанд ерөнхийлөгч нь парламентаа тарааж байсан.

Гэвч, хууль тогтоох байгууллага Парламент нь өөрийнхөө гаргасан хуулиудын дагуу Ерөнхийлөч болон засгийнгазрын үүрэг эрхийг хязгаарлах боломжтой, Үндсэн хууль зөрчиж гэмт хэрэг хийсэн нь тогтоогдвол төрийн тэргүүнээс огцируулж болох юм. Харин Ерөнхийлөгчийн хувьд хууль тогтоох байгуулагийн шийдвэрт хориг тавих эрх эдлэнэ. Казахстан улсын Үндсэн хуулийн63-р зүйлийн дагуу Парламент нь Засгийн газарт итгэл хүлээлгэхүй бол. Парламентын Мажилис, Сенат хоёрын дунд болон Парламент. Засгийн газар хоорондын эвлэрэшгүй зерчил үүсч улс төрийн хямрал үүссэн тохиолдолд Парламентыг тарааж болно гэж заасан байдал.

Ерөнхийлөгч асар их эрх мэдэлтэй. Хуулийн биелэлтэд хяналт тавих үүргийнхээ дагуу журамлах эрхтэй бөгөөд executive orders буюу гүйцэтгэх зарлиг болон тунхаг гаргаж эрхээ хэрэгжүүлнэ. Ерөнхийлөгч гадаад бодлогын салбарт нэн чухал эрх, үүрэгтэй. Дипломат харилцааны үйл явцыг хангаж, элчин сайд, консулуудыг томилох бөгөөд улс орнуудыг хүлээн зөвшөөрөх, хэлэлцээ хийх, гэрээ байгуулах бүрэн эрх эдлэнэ. Ерөнхийлөгч зэвсэгт хүчиний Ерөнхий командлагч бөгөөд цэрэг дайны үйлдлийн тухайд дээд эрхийг эдлэнэ. Ерөнхийлөгч төрийн тэргүүнүүдийн адил хилс хэргээр гүтгэгдсэн

⁵ М.Сланн Улс төрийн удиртгал, р 134

⁶ Хантов М. О Конституционная реформа в Туркменистане: новый этап «Право и политика» № 12. 2000

http://www.turkmenistan.ru/?page_id=9&lang_id=ru&elem_id=2251&type=event

<http://parliament.gov.uz/ru/constitution.php>

Глава XIX Президент Республики Узбекистан (Статьи 89 - 97)

⁷ “Үндсэн хуульд намзат өөрчилж оруулах въ Төрийн мэдээ змхэтгэл /Казахстан Улсын Төрийн Мэдээ/ 1990. №18

гэх төрийн том албан тушаалтанд тухайн хүн учлалт гүйсан тохиолдолд болон шоронд хоригдож буй зарим шалгууруудыг хангасан ялтанд өршөөл үзүүлнэ. Хямрал болоход ерөнхийлөгчийн эрх мэдэл нэмэгдэнэ.

Парламентын санал хураалтаар засгийн газарт, засгийн газрын тэргүүнд (Парламентын дарга, Ерөнхий сайд, Төрийн нарийн бичгийн даргад) тодорхой сайдад итгэл хүлээлгэх болон итгэл эс үзүүлэх вотумыг зарлах эрхтэй.

Ерөнхийлөч нь төрийн байгууллагын системд маш энгийн даруу үүрэгтэй, өөрөөр хэлбэл Үндсэн хуульт хаант төрийн ерөнхийлөгчтэй харьцуулбал ялгаа тун бага.

Төр улсыг Ерөнхийлөгч удирддаг ч, хууль тогтоох эрх нь парламентэд хадгалагдана, парламент нь тодорхой нэг албан тушаалтуудыг болон Ерөнхий прокурорыг томилохдоо зөвшеөрөл өгнө. Парламентийн хуулиуд нэг удаа олонхийн саналаар батлагдахгүй, хоёр удаа шалгагдаж, хэлэлцүүлэгт орж, дараа нь ерөнхийлөгч нь хориг тавих эрхээ эдэлж, парламентын гаргасан хуулиудыг батална. Үндсэн хуулийн зөвлөл нь дээрх хуулиуд нь Үндсэн хуульд харшилах зүйлгүй эсэхийг нь шалгадаг, харин шүүх эрх шүүхийн байгууллагын гартийн байдал. Шүүгч нар тодорхой хугацаанд эсвэл насаараа томилогдно.

Узбекстан, Туркменистан, Казахстанд ерөнхийлөгчийн гол онцлог нь:

1. Ерөнхийлөгчийг парламентгүйгээр ард түмний саналаар сонгодог, засгийн газраа өөрөө байгуулдаг
2. Засгийн газар нь Парламентаас илүүтэйгээр ерөнхийлөгчид ажлаа тайлагнана
3. Парламентын засаглалтай улсуудтай харьцуулахад эдгээр улсын ерөнхийлөгч нь өргөн мэдэлтэй

Ерөнхийлөгчийн засаглал Төв Азийн эдгээр улсуудад яагаад тохиромжтой байна вэ гэсэн асуултад төвийнхөдөр хариулт өгөхийг хичээ. Эдгээр улсууд нь 1991 онд ЗХУ-аас тасарч, тусгэр тогтоносон улс орнууд зах зээлийн хүнд зориултуудтай тулгарсан. Энэ үед олон “толгойлогч” биш дарга биш, нэг хүний удирдлага хатуу бүтэц бүхий Ерөнхийлөгчийн засаглал зөв зам байсан байж болох талтай. Энэ үедхуучин намын номенклатур бүлгийн хүмүүс бүх нийтийн сонгуулиар Ерөнхийлөгчийн суудалд гарч ирсэн. Хамгийн эхэнд дотоодын үйлдвэрлэл болон эдийн засгийн шилжилтээ зөв хийж, олон жилийн зорилтот хөтөлбөрүүд хэрэгжүүлж эхэлсэн. Төр засаг, засгийн газраа Ерөнхийлөгч бүрдүүлж, улсын төсөөв батлах, заршуулах, Ерөнхий сайд болон бусад салбарын сайд нарыг, өндөр албан тушаалтуудыг төдийгүй бүр муж нэгжийн захирагч нарыг томилж байсан. Одоо ч гэсэн орон нутаг, мужийн захирагчыг Ерөнхийлөгч нь томилно.

Ерөнхийлөгчийн засаглалтай Төв Азийн орнуудын эдийн засгийн хөгжил, ард түмний амьжиргаа нь жилээс жилд өдөр бүр дээшилсээр байгааг Дэлхийн банкны судалгаанууд харуулж байна. (Хүснэгт I-ээс ДНБ-ий өсөлтийг харж болно). Монгол улсыг харьцуулах зорилгоор оруулсан болно

Хүснэгт 1. Төв Азийн улс орнуудын эдийн засгийн өнөөгийн байдал⁸

Republic	2013 GDP/PPP Billions of USD
Uzbekistan	\$112.80
Kazakhstan	\$224.4
Turkmenistan	\$54.85
Tajikistan	\$8. 508
Kyrgyzstan	\$7,226
Mongolia	\$11.52

Хамгийн амжилттай жишээ улс нь Казахстан. Казахстаны Ерөнхийлөгч Н.Назарбаев нь 20 жилийн хугацаанд Ерөнхийлөгчийн засаглалын алдаа онооны аль алиныг Төв Азид харуулсан. Эдийн засгийн шилжилтээ хамгийн эхэнд хийсэн. Казахстан улсын «Ата Зан» Үндсэн хууль⁹ буюу Эцэг хууль; Үндсэн хуулийг парламентаар батлуулсан. Парламентийг Мажилис болон Сенат гэж хоёр танхимаар бүрдүүлсэн. Бүх нийтийн сонгуулиар ард түмэн мажилис, сенатын гишүүдийг сонгодог.

Казахстан улсын тусгаар тогтолц, бүрэн бүтэн байдал, аюлгүй байдлыг хамгаалах, эв найрамдлыг эрхэмлэх, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, Ерөнхий сайд, дэд сайдууд, Гадаад хэрэг, Батлан хамгаалах, Сангиийн сайд, Дотоод хэргийн сайд, Аюлгүй Байдлын Хорооны дарга болон дипломат төлөөлөгч, элчин сайд нарыг томилохос гадна Ерөнхий сайдын санал болгосноор зарим сайдыг томилдог, ЗГ-ын

⁸ Data.worldbank.org/region/ECA

⁹ “Казахстан Улсын үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах нь (Казахстан Улсын Төрийн Мэдээ эмхэтгэл, 1998, № 20.).

хэрэг эрхлэх газар яам газруудыг бүрдүүлж мөн тараадаг.¹⁰

Эдийн засгийн зорилтот «Казахстан-2020, 2030, 2050» г.m хөтөлбөрүүд боловсруулж, хэрэгжүүлж ажиллаж байна. 2050 он гэхэд дэлхийн хөгжлийг 50 ороонд багтах зорилго нь эхнээсээ үр дүнгээ харуулж байна. Улсын баялаг, газар доорх баялаг маш зөв зохицойгоор хуваарилагдах байна. Акау, Атырау хотуудын эргэн тойронд байдаг байгалийн хийн ордуудын ашгийгард түмэн хүртэх давамгай эрх олгосон байдаг. Ураны том нөөцийг нь Францын компаниудтайхамтран ашиглаж байгаа. Ураны нөөцөөр дэлхийд эхний 1-д ордог Казахстаны хувьд эдийн засгaa хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого явуулж байна. Үүнээс харахад Хятад улс хий дамжуулах хоолойг Казахстаны нутаг дэвсгэрээр дамжин ёнгөрөөх болсноор Евро Азийн холбогч гүүр болохын хажуугаар эдийн засгийн болон ажлын байрны том боломжийг бий болгов.

Эдийн засаг ийнхүү тогтвортой өсөж байгаа шалтгаан нь сонгож авсан засаглалын хэлбэртэй нь мэдээж холбоотой. Учир нь хэн хариуцах нь мэдэгдэхгүй олон сайд дарга нараас хариуцлага хүлээх хүн нь тодорхой байдалд гадаадын хөрөнгө оруулагчид айх зүйлгүй хөрөнгө оруулж байгаа нь илэрхий байдаг.

Нийслэл Алматыгаас Астана руу нүүж, стратеги бодлого хэрэгжүүлсэн. Учир нь Алматы хот нь газар хөдлөлт их аюултайбусийн нэг. Нийслэлийг Астанад шилжүүлсэн нь үр ашгаа өгч, ард түмний итгэлийг хүлээв. Хэдийгээр нэг хүний дарангуйллын системтэй харагдavч залуусын дээд боловсролоо үнэгүй авч, «Болашак» буюу Ирээдүй хөтөлбөрөөр 1991 оноос эхлээд Казахстаны шинэ боловсон хүчинчлийг Америк, Баруун Европт бэлтгэж байна. Төгсөгчид нь 16,000 орчим хүн бол одоо сурч байгаа нь 6,300 хүн байна. Энэ бол тэр чигтээ Казахстаны төрд үе солигдсон Зөвлөлт сэтгэлгээний халааг Америк, Европ маягын залуусхууч түрэн авах болж байна гэсэн үг. Боловсон хүчиний бодлого нь залгамж шинжлэгээний, дарга вөрчлөгдсөн ч тухайн байгууллагын мэргэжлийн хүмүүс үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломж бий болгосон гэсэн үг.

Ардчиллын хэмжүүрээр хамгийн диктатуртай Туркменстан улс нь газрын баялаг, хийн асар их нөөцтэй. Үүгээрээ тулгуурлан хөрш орнуудтайгаа улс төрийн тогтолцыг амжилттай хийж байна. Туркменстан улсад ард түмэн нь байгалийн хийг үнэгүй ашигладаг¹¹, энэ бол халаалт, дулааны асуудал бүрэн шийдэгдсэн гэсэн үг. Дээд боловсрол нь үнэгүй..

Туркменийн эцэг болсон "Туркменбашы" Сапармурат Ниязовын дараах Ерөнхийлөгч Гурбангулы «Аскар тау», Оргил уул гэсэн нэр хүнд хүртсэн. Ерөнхийлөгч Гурбангулы Үндсэн хуулиар олгогдсон эрх үүргийн дагуу Казахстаны Ерөнхийлөгчтэй төстэй эрх мэдэлтэй. Сайд, дарга нар болон мужуудын захирагчыг томилдог. Засгийн газар нь Ерөнхийлөгчид ажлаа тайлгаж, Ерөнхийлөгч нь загийн газарт хариуцлага хүлээлгэдэг. Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн байхаас гадна Засгын газрын тэргүүн нь юм. Учир нь Туркменстан улсад Ерөнхий сайдын албан тушаал байдаггүй, үүнийг орлох Сайд нарын танхимиын дарга гэх албан тушаал байдаг. Сайд нарын танхимиын дарга нь Ерөнхийлөгч Гурбангулы юм.

Туркменстан улс нь цөлд дээр гайхалтай хот боосгосон ажилсаг ард түмэн. Ашхабад нь гадаадын олон хүний сонирхлыг их татахуйц хот юм. Азид гайхуулах маш том номын сантай. Зургаан давхар энэхүү номын сангын анхны суурь нь анх 1885 онуудад боссон гэдэг. Тус улс нь Узбекстан, Казахстаныг бодвол хаалттай, үндсэргээг үзэлтэй улс юм. Узбекистан, Казахстанд албанёсны хэл казах, узбек хэлтэй эн тэнцүү оросхэлийг хэрэглэхийг заасан бол Туркменстаны албан ёсны хэл нь зөвхөн туркмен хэл юм. Ерөнхийлөгч Гурабнгуль нь Асхар тау гэсэн хүндэл хүлээж, ард түмний итгэлт хүн нь байсаар л байна.

Туркменстан улсыг нефть болон газын «Бассейн» гэж хэлж болно. Энэхүү асар их эдийн засгийн ашгаа ард түмэн нь хүртээж байгаа нь сайшаалтай. Туркменстан улс хаалтай улс болохоор ямар бодлого, бүтээн байгуулалт хийгдэж байгааг тэр бүхэн хүмүүсийн нүдэнд ил тод биш ч үнэн хэрэгтээ эрчимтэй хөгжик буй улс юм. Казахстаны Астана хотыг олон хүн мэдэж байгаа бол Ашхабад нь аль хэдийнээ Төв Азийн цөлийн ногоон хот Дубай болчихсон болов уу. Туркменстан газрын тосны инженерүүдээ Иран, Арабт бэлтгэж байгаа бол (7000). эдийн засгийн чиглэлээр Туркэд, химич, биотехнолог, барилгын инженер болох боловсон хүчин, залуусаа Малайзид сургаж байна.

Узбекистан улсын Ерөнхийлөгчийн засаглалыг авч узвэл Казахстан улстай ихээхэн төстэй¹². Үндсэн хуулиаар өгөгдсэн эрх үүрэг нь ч адилхан юм.¹³ Энэ улс нь Төв Азид ард түмэндээ их ээлтэй улсад тооцогддог. Ард түмгий амьжирааны түвшин дээгүүр, чинээлэг амьдралтай. Дэлхийд алтны нөөцөөр 4-д, ураны нөөцөөр 7-д, молибдений нөөцөөр 8-д ордог Узбекстаны хөгжил нь ерөнхийлөгч И.Каримовын

¹⁰ Constitution RK

¹¹ Время и деньги | Общество | На смену Daewoo Matiz придет Chevrolet Spark | Выпуск: 175 (2136)

¹² Конституция Республики Узбекстан

¹³ Закон об основных гарантиях деятельности Президента

бодлого, үйл ажиллагаатай холбоотой. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа нь Казахстаны ерөнхийлөгчтэй адил 7 жил, ард түмэн ерөнхийлөгчээ сонгоно. Парламент нь (Оли Мажилис буюу Их Хурал) нь хоёр танхимтай.

Ерөнхийлөгч нь бүх төрийн байгууллагын дарга нарыг сайдуудаа томилдог, яамдуудыг байгуулах эрх үүрэгтэй. Узбекстан улсын эдийн засаг нь Төв Азид дээгүүрт орно. Энэ нь олон янзын шалтгаантай. Жилд хоёр удаа ургац авдаг. Хүнс, ногооны нөөц дотооддоо хангалитай хүрэлцэхийн хажуугаар хөрш орнуудад экспортод гаргадаг. Аж ахуй хөгжсөн. Торго болон хөөвөн эдлэлийн олон жижиг үйлдвэр үйл ажиллагаа явуулдаг. И.Каримовын хамгийн анхаарал хандуулсан салбар нь хүнд болон хөнгөн үйлдвэрлэл, тодруулбал машин үйлдвэрлэл юм. Гадаадын тансаг зэрэглэлийн машин хэрэглэх нь манай ард түмэнд ашиглгүй, үүний оронд тийш урсдаг мөнгийг эх орондоо байлгахаар Солонгосын Daewoo компанийтай хамтарч GM Uzbekistan, UzDaewoo, UzAutoSanoat компаниудыг байгуулсан. Андижан мужийн, Atkas хотод байрладаг машины үйлдвэр нь Damas, Matiz, Nexta, Lacetti, Spark¹⁴ илрүүийн автобус, машинуудыг үйлдвэрлэжард түмэндээ боломжийн үнэтэй машин унах боломж бүрдүүлж егөв. Өрийн машинаа бүтээж боловсон хүчнийг бэлтгэж байна. Мөн түүнчлэн инженер, химич залуусаа Америк болон ХБНГУ-д олноор явуулж сургаж байна.

Узбек улсын үйлдвэрлэсэн том оврын болон жижиг машинуудыг хөрш орнууд, ОХУ олон тоогоор худалдан авч байна. Зөвхөн 2011 онд Узбекситанд үйлдвэрлэгдсэн машины тоо 175.000 байв. Үүний 21773 нь ОХУ-д зарагдсан нь энэ улс дотоодын эдийн засагтаяа хэр хэмжээний хөрөнгө оруулж байгааг харуулна.

Эдгээр жишээнүүдийг харахад улс орон, ард түмэндээ наалдаацтай цогц шийдмэг бодлого явуулдагаараа байгаа эдгээр ерөнхийлөгчидийг ард түмэн нь хүндэтгэх нь тийм буруушаах зүйл биш гэж бодож байна.

Туркменстан, Казахстан, Узбекистаны ерөнхийлөгчид үнэн хэрэгтээ ард түмнээ шинэ шатанд, элбэг хангалаан амьдралд гаргаж чадаж байна.¹⁵ Парламентаа удирдаж, эх орноо зөв чиглүүлж байгаа нь Төв Ази шиг олон үндэстэн, ястан бүрэлдсэн улсуудад Ерөнхийлөгчийн засаглал хамгийн тохиромжтой засаглалын хэлбэр байж болох нь харагдаж байна.

Парламентын болон ерөнхийлөгчийн тогтолцооны нэн чухал ач холбогдол бүхий өөр нэг ялгаа нь парламентын гүйцэтгэх эрх мэдэл хамтын шинжтэй байдаг бол харин ерөнхийлөгчийн гүйцэтгэх эрх мэдэл нэг хүний танхимиын шинжтэй байдагт оршино.¹⁶ Ерөнхийлөгчийн тогтолцоонд гүйцэтгэх эрх мэдэл ерөнхийлөгчийн гарг төвлөрт танхим нь зөвлөхүүдээс бүрддэг бол парламентын засгийн газрын гишүүд харилцан бараг ижил эрх мэдэлтэй гишүүдээс бүрдэнэ. Нэг намын эсвэл эсслийн гүйцэтгэх засгаас ялгарахын хувьд энэ нь юу гэсэн уг вэ гэвэл ерөнхийлөгчийн танхимиыг нэг намын танхимгэж тодорхойлдэг.¹⁷ Учир нь тухайн танхимдахь ерөнхийлөгчийн зонхилох байр суурь статусын улмаас уг нам нь ерөнхийлөгчийн намбайх болно. Нөгөө талаас ерөнхийлөгч намын гишүүдээ намаасаа бүрдүүлэх үү эсвэл өөр нэг хоёр намын гишүүдийг оролцуулахуу гэдгээс онцын ялгаа ерөөс гарахгүй.

Улс төрийн шинжлэх ухаанд засаглалыг ойлгох, түүнийг тайлбарлахад чиглэсэн олон янзын үзэл санаа, хандлагууд байдаг. Учир нь засаглалын агуулгаа хамааран улс төрийн үйл явц ба институт тэрчлэн хувь хүн, нийгмийн бүлгүүдийн ашиг сонирхол, улс төрийн үйл байдлын мөн чанар, хэрэгжих арга механизмын тодорхойлогддог. Улс төрийн засаглалыг эзэмших, хуваалцах, эсвэл хязгаарлах, эсргүүцэх, түүнээс зугтаахын төлөө тэмцэл нь улс төрийн бодлогын үндсэн агуулгыг илэрхийлдэг. Тиймээс улс төрийг судалдаг шинжлэх ухааны гол судлагдахуун нь засаглалын тухай асуудал мөн.

Польшийн улс төр судлаач Е.Вятр засаглалд оролцох сэдэл, шалтгааныг зургаан янаар тодорхойлсон байдаг¹⁸. Үүнд;

- Бихевиорист засаглалд оролцогчдын үйл байдлын хэв шинж
- Теологи зорилгодоо хүрэх арга зам
- Арга хэрэгслийн бусдаа өөрийн нөлөөллийг бий болгох механизм
- Структуралист удирдах удирдуулах харилцааны төрөл
- Зөрчлийн зөрчилт нхцэлд баялагийн хуваарилалт хийх шийдвэр гаргах олон боломжуудыг ашиглах
- Засаглал болнөлөөллийн харилцаа гэж үзэх

Ардчиллын шалгуураар авч үзвэл Төв Азийн эдгээр орнууд маань дарангуйллын шинж тэмдгийг

¹⁴ <https://ru.wikipedia.org/wiki/UzDaewooAuto>

¹⁵ Моделирыйн ковицных бумаг Авторы: Борис Михайлович Ческидов

¹⁶ ArendLiphard 1992. Parliamentary versus presidential government Oxford University Press

¹⁷ Pollard, A. F., The Evolution of Parliament, 2d ed. (1926, repr. 1964); Punnett, R. M., Front Bench Opposition (1973);

¹⁸ World politics

агуулж байна гэж судлаачид үздэг. Эдийн засаг нь эрчимтэй хөгжиж, хүмүүсийн амьжиргаа нь дээшилж, ард түмэн нь эдийн засгийн эрхээ эдэлж байгаа боловч улс төрийн эрхээ бүрэн эдэлж чадахгүй байгаа нь анзаарагддаг. Улс төрийн эрхэнд хүний эрх, эрх чөлөө, угээ чөлөөтэй хэлэх, үхэл бодлоо илэрхийлэх, шударгаар сонгууль явуулах гэл олон зүйлийг дурдаж болно. Төв Азийн улс орнуудад бодлог сонгуулийн ихэнх нь билгэдлийн маягтай болж өнгөрдэг гэж гадныхан шүүмжилдэг. Гэвч Төв Азийн орнуудын Турбангулы. Каримов; Назарбаевын дараа сонгогдохзалгамж халаа нь нь Америк. Европт боловсрол эзэмшсэн технократ боловсон хүчинүүд юм. Америк маягын, либерал сэтгэлгээт боловсон хүчинүүд гарч ирснээр тухайн улсуудад ардчиллал хөгжиж боломж бүрэн байгаа гэж хэлж болно. Зөвлөлт сэтгэлгээний хүмүүс төр засгын эрхээс аажмаар явах үед тэдний орон зайл шинэ үе, баруунд боловсрол эзэмшсэн, либерал сэтгэлгээт боловсон хүчинүүд орлох болсноор Төв Азид ардчилал хөгжих боломжууд нэгдэж, аажмаар парламентын засаглалд шилжих оролдлогууд хийгдэж болох юм. Учир нь Төв Ази энэ хэвээрээ үүрд Ерөнхийлөгчийн засаглалтай үлдэнэ гэж хэлэхэд хэцүү юм.

ДҮГНЭЛТ

Ерөнхийлөгчийн болон парламентын засаглалын гол ялгаа нь парламентын системд гүйцэтгэх эрх мэдэл олонхийн дэмжлэгийг зөвхөн ерөнхийлөгчийн хуулийн төслийг батлуулахад шаардлагатай. Ерөнхийлөгч эрх мэдлээ хэрэгжүүлэх тодорхой хугацаагаар ерөнхийлөгч өрөө болон түүний томилсон танхим хууль тогтоогчдын итгэл үл үзүүлэх эсэхээс огтхон ч хамааралгүй оршин тогтнодог. Ийм учраас нэг талаас албан тушаалдаа байх утгаараа бол ерөнхийлөгч түүний танхим ялимгүй олонхийн хэлбэртэй, нэгөө талаас хуулийн төслөө дэмжүүлэхэд парламентын дэмжлэг авах утгаараа бол ялимгүй олонхийн, хэт олонхийн бүр цөөнхийн танхимиын аль нь ч байж болно. Чухамямар хэлбэртэй байх нь ерөнхийлөгч ба түүний танхимиин гишүүдийн намын харьялал, тухайн намуудын парламент дахь нөлөө хэмжээ зэргээс хамаарна. Энэ утгаараа парламентын системд ялимгүй олонхийн танхимиын хэмжээ 0-100 хувийн хооронд хэлбэлзэж байдаг бол ерөнхийлөгчийн танхимиын хувьд энэ хэмжээ 50-100 хувийн хооронд байдаг байна.

Сүүлийн үед Монгол улсад Үндсэн хуульд өөрчлөлт оруулж Ерөнхийлөгчийн засаглал тогтоох тухай яридаг хүмүүс бий болов . УИХ их үзэмжгүй хэрэлдэж буй нь Монголд парламентын засаглал хямарсны буюу зохицгүй илрэл мөн гэж бодож байна.

Туркменстан, Казахстан, Узбекстаниг харж байгаад нэг хүний удирдлагадоор яаж эдийн засаг хөгжиж байгаа нь сайшаалтай хэрэг ч улс төрийн эрхээ эдлэх нь эдгээр улсуудад маш бага байдал. Билгэдлийн чанартай сонгууль болж явдаг, сөрөг хүчиний нөлөө бараг байхгүй. Харин Монгол улсын хувьд Ерөнхийлөгчийн засаглалтай байж болох ч энэ нь Монгол улсын хувьд тийм найдвартай засаглал байж чадахгүй мэт. Учир нь Орос , Хятад гэх хоёр том гүүрний дунд оршдог Монгол улсын хувьд одоогийн хуулийн зохицуулалтаар Парламентын засаглалтай, олон удирдагчтай. Хэрэв ганц хүний удирдлага, ерөнхийлөгчийн засаглалтай болчихвол эл хоёр хөрштэй эл тэнцүү харилцаж чадах эсэх нь тодорхой биш, шийдвэр гаргах эрх мэдэлтэй Ерөнхийлөгч нь аль нэг улсын нөлөөнд автаж магадлал маш өндөр. Тиймээс аюлгүй байдлын үүднээс болон геополитик, газар зүйн байрлал, элийн засгын боллогын үүднээс харахад Монгол улсыг Орос эсвэл Хятадын нөлөөнд орохоос сэргийлэх, аль нэг улсад эдийн засгаараа хараат болох аюулаас сэргийлж чадах хамгийн тохиромжтой засаглал бол Парламентын засаглал мөн гэж үзэж байна. Парламентын засагтай байснаар Монгол улсын ард түмэн улс төрийн эрхээ эдэлж, сонгож, сонгогдож, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж, Фейсбукуг м. социал медиагаар болон сонгосон төлөөлөлөөрөө дамжуулж үгээ хэлж, ардчиллын хэмжүүрээр ардчиллал амжилттай хэрэгжиж буй орны тоонд орж байна. Гагцхүү улс төрийн эрхээ эдлэхийн хамтаар эдийн засгийн эрхээ эдлүүлэх бодлогыг төр засаг хэрэхжүүлэх хэрэгтэй гэж үзэж байна.

НОМ ЗҮЙ

1. Казахстан Улсын үндсэн Хууль
2. Узбекстан улсын Үндсэн хууль
3. Туркменстан Улсын Үндсэн Хууль
4. Алебастрова И.А. Конституционное право зарубежных стран. Москва, 2001
5. "Turkmen President Reelected With 97 Percent Of Vote", in Eurasia.net, February 13th 2012
6. 3.Kislav, D.: Who and what's behind the riots in Kazakhstan?, The Journal of Turkish Weekly, December 26.
7. Nazarbayev in Kazakhstan; Karimov in Uzbekistan; and Rahmon in Tajikistan. Rahmon rose to the presidency in Tajikistan in November 1992.
8. Niyazov, in Turkmenistan; followed on his death in 2006 by Berdymukhammedov.
9. Nelson, D. (2008). ana D. Bad for Democracy: How the Presidency Undermines the Power of the People.
10. Bender, Thomas (2006). A Nation Among Nations: America's Place in World History. New York: Hill & Wang. p. 61.
11. Governing Systems and Executive-Legislative Relations. (Presidential, Parliamentary and Hybrid Systems), United Nations Development Program
12. М.Дюверже. Улс төрийн байгууламж, үндсэн хуулийн эрх зүй
13. М.Сланн. Улс төрийн удиртгал
14. Хайтов М. О. Конституционная реформа в Туркменистане: новый этап «Право и политика» № 12, 2000
15. Алексей Тихорецкий, Главный ресурс национального благосостояния
16. Елена Долгова — Работать по-новому // Электронная газета «Туркменистан: золотой век», 25.01.2013
17. Модели рынков ценных бумаг
18. Авторы: Борис Михайлович Ческидов
19. Arend Lijphard. 1992. Parliamentary versus presidential government. Oxford University Press
20. Pollard, A. F., The Evolution of Parliament, 2d ed. (1926; repr. 1964);
Punnett, R. M., Front Bench Opposition (1973);
21. World politics , Oxford press, 2001